

ЗӨВШӨӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

*Б.Батцэцэг*

Б.БАТЦЭЦЭГ

## ТАНИЛЦУУЛГА

1. *Наваан-Юндэнгийн Оюундарийг Бүгд Найрамдах Польш Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилуулахаар танилцуулж байна.*

2. *1973 онд Улаанбаатар хотод төрсөн.*

3. *51 настай*

4. *Эмэгтэй*

5. Гэр бүлийн байдал: *Нөхөр, 2 хүүхэдтэй*

6. Хэзээ, хаана ямар сургууль, дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

*1991 онд Политехникийн их сургуулийг Гадаадын инженерийн бэлтгэл, 1991-1995 онд "Сэрүүлэг" дээд сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгсөж, 1997-1998 онд Нидерландын Хаант Улсын Маастрихтын их сургуульд бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд 2016-2020 онд "Эрх зүйч" мэргэжлээр сурч төгссөн. Бизнесийн удирдлага, эрх зүйч мэргэжилтэй. Орос, Англи, Герман, Хятад хэлний мэдлэгтэй.*

7. Ажилласан байдал:

*1995 онд Монголын Үндэсний Бүтээмжийн Төвд зөвлөх, 1996 онд Монголын Бизнесийн хөгжлийн агентлагт Европын Холбооны ТАСИС хөтөлбөрт зөвлөх, 1998 онд НҮБ-ын Аж үйлдвэрийн хөгжлийн агентлагийн өөрчлөн байгуулалтын төсөлд зөвлөх, 1997 оноос Баатарван Наваан-Юндэн сан ТББ-ийн тэргүүн, 1999 онд Дэлхийн Банкны Олон улсын санхүүгийн корпорацын Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төсөлд зөвлөх, 2004-2006 онд Байгаль орчны яамны хамтын ажиллагааны хэлтсийн дарга, НҮБ-ын "Биологийн төрөл зүйл"-ийн конвенцын талуудын бага хурлын дэд дарга, 2004-2007 оны Байгаль орчны яамны Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын дарга, 2008-2012 онд НИТХ-ын төлөөлөгч, 2009-2012 онд Бээжин хот дахь Улаанбаатар хотын төлөөлөгч, 2012-2014 онд "Блюмон групп"-ын зөвлөх, 2014-2015 онд Гадаад харилцааны Дэд сайд, 2016-2020 онд УИХ-ын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга, 2020-2023 онд "Блюмон групп"-ын зөвлөх, 2023 оноос одоог хүртэл МАН-ын ЕНБД-ын зөвлөхөөр ажиллаж байна.*

8. Ажилласан хугацаа (жилээр):

*Төрийн албанд 16 жил*

*Дипломат албанд 1 жил*

9. Энэ иргэнийг тухайн албан тушаалд томилуулах (чөлөөлүүлэх) үндэслэл:

*Мэргэжлийн ур чадвар, удирдах ажлын дадлага туршлага, гадаад хэлний мэдлэгийг харгалзан энэхүү албыг хаших бүрэн боломжтой гэж үзэж байна.*

10. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан мэргэшлийн шалгалтын дүн

11. Энэ асуудлыг шийдвэрлүүлэх (хэний санал ирсэн)-ээр бэлтгэсэн

*Гадаад харилцааны сайдын саналаар*

12. Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт

Хянасан:

*Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалтын газар /ТЗХНУЗБГ/-ын захирал*

Боловсруулсан: *ТЗХНУЗБХ-ын хоёрдугаар нарийн бичгийн дарга*

*Д.Булган  
Т.Эрдэнийнчулуу*

13. Албан тушаалд томилох үед өгсөн үүрэг, зөвлөмж

*2024 оны 12 дугаар сарын "13"-ны өдөр*

